



ДУНДГОВЬ АЙМАГ  
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 27 өдөр

Дугаар 1/13

Хажуу шинэ ус

Газар эзэмшүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйл, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3 дахь заалт, 33 дугаар зүйлийн 33.1.1 дэх заалт, Говь-Угтаал сумын иргэдийн төлөөлөгчдийн 2021 оны 12 дугаар сарын 16 ны өдрийн №25 тоот тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Говь-Угтаал сумын 1,2,3 багийн дөрвөн иргэнд өвөлжөө, хаваржааны зориулалтаар 2,5га газрыг нийт 5 иргэнд хавсралтаар баталж эзэмшүүлсүгэй.
2. Иргэдэд газар эзэмших хугацааг 15 жил, газрын хэмжээг 5000м<sup>2</sup> байхаар олгохыг газрын даамал /Б.Хорол/-д үүрэг болгосугай.
3. Эзэмшил газрын хил заагийг тогтоон, газрыг хүлээлгэн өгч, гэрээ байгуулан гэрчилгээ олгож, гэрээний биелэлтэд хяналт тавьж ажиллахыг газрын даамал /Б.Хорол/-д даалгасугай.
4. Газрыг зориулалтын дагуу байгаль орчинд сөрөг нөлөөлөлгүйгээр эзэмшиж гэрзэнд заасан үүргээ биелүүлж байхыг газар эзэмшигч иргэдэд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Ө.МӨНХ-АМГАЛАН

